



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2001 оны 8 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 260


Улаанбаатар  
ХОТ

Гадаадад суралцуулах тухай

2001-2002 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Баасандорж овогтой Долгорсүрэнг АНУ-ын Пүрдүгийн Их сургуулийн докторантурт боловсрол судлалын чиглэлээр 3 жилийн хугацаагаар, Батаа овогтой Тэмүүлэнг ХБНГУ-ын Байройтын Их сургуулийн докторантурт хууль зүйн чиглэлээр 3 жилийн хугацаагаар, Пүрэвжав овогтой Гандолгорыг АНУ-ын Калифорнийн Олон улсын Их сургуулийн магистрантурт олон улсын бизнесийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Цэгмид овогтой Энхмааг Англи улсын Эксэтэрийн Их сургуулийн магистрантурт англи хэл заах арга зүйн чиглэлээр 1 жилийн хугацаагаар тус тус 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД  А.ЦАНЖИД

Хуучин үзэм: ТЗР-АТ 2001.8.15

2001 оны 08 сар 15 өдөр

Сургалтын газар 38818

УБ-ийн захирал /М.Баасанжав/